



ᠬᠢᠨᠠᠯᠲᠤ ᠰᠢᠯᠠᠭᠠᠯᠲᠤ
ᠠᠵᠤᠯᠢᠨ ᠰᠢᠷᠢᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН САРЫН МЭДЭЭ

(2022 оны 05.01-07.06)

АГУУЛГА

НЭГ. ТҮР ХОРОО, ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

2.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

2.1.1. Үйл ажиллагаа үргэлжилж байгаа ажлын хэсэг

2.2. БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

2.2.1. Үйл ажиллагаа үргэлжилж байгаа ажлын хэсэг

2.2.2. Үйл ажиллагаа дуусгавар болсон ажлын хэсэг

2.3. ДЭД ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТ

3.1. АСУУЛГА

3.2. АСУУЛГЫН ХАРИУ

3.3. АСУУЛТЫН ХАРИУ

3.4. АСУУЛТ, АСУУЛГЫН ХАРИУГ ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ТАЛААР

ДӨРӨВ. ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

4.1. ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ

4.2. БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНД СОНССОН МЭДЭЭЛЭЛ

ТАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

5.1. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

ЗУРГАА. ТӨСВИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ



НЭГ. ТҮР ХОРОО, ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО

Хүснэгт 1. Улсын Их Хурлын тогтоолоор байгуулагдсан түр хороо, хянан шалгах түр хороо

Д/д	Түр хороо, хянан шалгах түр хороо байгуулсан тогтоол	Түр хороо болон хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүн
1.	2020.10.29 №31 Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай /КОВИД-19/	<p>Түр хорооны дарга: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр</p> <p>Түр хорооны гишүүд: УИХ-ын гишүүн Х.Болорчулуун - БОХХААБХ, Ж.Мөнхбат - БСШУСБХ, Б.Бат-Эрдэнэ - ЁЗСХБХ, Н.Учрал - ИЦББХ, М.Оюунчимэг - НББХ, Л.Энх-Амгалан - ТББХ, Б.Жавхлан - ТБХ, Б.Чойжилсүрэн - ҮББХ, С.Бямбацогт - ХЗБХ, Ж.Ганбаатар - ЭЗБХ-ны дарга нар болон Б.Бейсен - УИХ дахь АН-ын төлөөлөл, С.Ганбаатар - УИХ дахь “Та бидний эвсэл”-ийн төлөөлөл, Т.Доржханд - УИХ дахь “Зөв хүн электорат эвсэл”-ийн төлөөлөл, Н.Алтанхуяг - Бие даагч</p> <p>ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Ц.Рэнцэнтогтох, Х.Хэрлэн</p>
2.	2022.04.15 №14 Хянан шалгах түр хороо байгуулах тухай /Хөгжлийн банкны асуудлаарх/	<p>Түр хорооны дарга: УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар</p> <p>Түр хорооны гишүүд: Олонхыг төлөөлөн: УИХ-ын гишүүн Д.Батлут, Э.Батшугар, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Л.Мөнхбаатар, Ц.Мөнхцэцэг, Б.Энхбаяр</p> <p>Цөөнхийг төлөөлөн: Ж.Батсуурь, Н.Ганибал, Т.Доржханд, Д.Ганбат /24-р тогтоолоор/</p> <p>ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: ХШХ-ийн дарга Ж.Лхагвасүрэн, референт Ц.Рэнцэнтогтох</p>
3.	2022.05.19 №21 Хянан шалгах түр хороо байгуулах тухай /Хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаарх/	<p>Түр хорооны дарга: УИХ-ын гишүүн Н.Учрал</p> <p>Түр хорооны гишүүд: Олонхыг төлөөлөн: УИХ-ын гишүүн П.Анужин, Д.Батлут, Э.Батшугар, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ж.Чинбүрэн,</p> <p>Цөөнхийг төлөөлөн: Б.Бейсен, С.Ганбаатар, Т.Доржханд, С.Одонтуяа, Ц.Туваан</p> <p>ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Д.Гэрэлт-Од</p>
4.	2022.06.10 №31 Хянан шалгах түр хороо байгуулах тухай /Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх асуудлаарх/	<p>Түр хорооны дарга: УИХ-ын гишүүн Г.Ганболд</p> <p>Түр хорооны гишүүд: Олонхыг төлөөлөн: УИХ-ын гишүүн Ц.Анандбазар, Б.Баттөмөр, Л.Мөнхбаатар, Г.Мөнхцэцэг, Н.Наранбаатар, Т.Энхтүвшин</p> <p>Цөөнхийг төлөөлөн: УИХ-ын гишүүн Ш.Адъяаа, Б.Бейсен, С.Ганбаатар, Н.Ганибал, Т.Доржханд</p> <p>ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: ТХШХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу, референт Х.Хэрлэн</p>

2022 оны 5 дугаар сарын 01-нээс 7 дугаар сарын 06-ны хугацаанд Улсын Их Хурлын тогтоолоор тодорхой асуудлыг шалган судалж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хорооны үйл ажиллагааны мэдээлэл:



1. Улсын Их Хурлын 2020 оны 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол УИХ-ын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хорооны үйл ажиллагаа:

- Түр хорооноос өгсөн чиглэлийн дагуу Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, авч буй арга хэмжээний талаарх мэдээллийг тогтмол авч, холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- 2022.05.04, 2022.05.24-ний өдрийн хуралдаанууд хойшлогдсон.
- 2022.06.07-ны өдрийн хуралдаанд “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын нөхцөл байдал, шинэ төрөл, чиг хандлага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, зөвлөмж” сэдвээр Эрүүл мэндийн сайд С.Энхболд мэдээлэл хийсэн.

2. Улсын Их Хурлын 2022 оны 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдлыг шалгах үүрэг бүхий түр хорооны үйл ажиллагаа:

- УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2022.04.18-ны өдрийн 235 дугаар захирамжаар Хянан шалгах түр хорооны ажлын албыг байгуулсан.
- 2022.05.17-ны өдрийн Түр хорооны хуралдаанаар Хөгжлийн банкны мэдээлэл сонссож, Түр хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцсэн.
- 2022.05.31-ний өдрийн хуралдаанаар Хөгжлийн банкны асуудлаарх цаг үеийн мэдээлэл сонсон, “Нотлох баримт гаргуулах тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг хэлэлцэн баталсан.
- 2022.06.07-ны өдрийн хуралдаанаар Сангийн сайд Б.Жавхлан мэдээлэл хийж, “Хянан шалгагч томилох тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг хэлэлцэн баталсан.
- 2022.07.06-ны өдрийн хуралдаанаар Хөгжлийн банкны асуудлаар цаг үеийн мэдээлэл, Хянан шалгагч нарын шалгалтын ажлын явцын танилцуулгыг хаалттай хуралдааны горимоор хэлэлцсэн.

3. Улсын Их Хурлын 2022 оны 21 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаар Монгол Улсад эмийн хяналт шалгалтыг сайжруулах, эсхүл хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох талаарх саналыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий түр хорооны үйл ажиллагаа:

- УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2022.06.09-ний өдрийн 340 дүгээр захирамжаар Хянан шалгах түр хорооны ажлын албыг байгуулсан.
- 2022.06.28-ны өдрийн хуралдаанаар Түр хорооны даргаар УИХ-ын гишүүн Н.Учралыг сонгож, Түр хорооны даргыг сонгох тухай 01 дүгээр тогтоолыг батлав.

4. Улсын Их Хурлын 2022 оны 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоож Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий түр хорооны үйл ажиллагаа:

- УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2022.06.30-ны өдрийн 374 дүгээр захирамжаар Хянан шалгах түр хорооны ажлын албыг байгуулсан.
- 2022.06.30-ны өдрийн хуралдаанаар Түр хорооны даргаар УИХ-ын гишүүн Г.Ганболдыг сонгож, Түр хорооны даргыг сонгох тухай 01 дүгээр тогтоолыг батлав.



ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт


2022 оны 5 дугаар сарын 01-нээс 7 дугаар сарын 06-ны хугацаанд хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэгтэй байгуулагдсан нийт 23 ажлын хэсэг (давхардсан тоогоор Улсын Их Хурлын 166 гишүүн ажилласан) байна.

Үүнээс:

- УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан 3;
- Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан 19;
- Дэд хорооны тогтоолоор байгуулагдсан 1 ажлын хэсэг байна.

График 1. Хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан нийт ажлын хэсгийн статистик мэдээ /байгуулагдсан хугацаагаар/

- 2020 оны намрын ээлжит чуулганы болон завсарлагааны хугацаанд байгуулагдсан (6)
- 2021 оны хаврын ээлжит чуулганы болон завсарлагааны хугацаанд байгуулагдсан (5)
- 2021 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан (8)
- 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан (4)



Хүснэгт 2. Хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан нийт ажлын хэсгийн статистик мэдээ /тогтоол, захирамж, шийдвэрийн төрлөөр/

Хугацаа	УИХ-ын даргын захирамж	Байнгын хорооны тогтоол	Дэд хорооны тогтоол
2020 оны намрын ээлжит чуулганы болон завсарлагааны хугацаанд байгуулагдсан	1	4	1
2021 оны хаврын ээлжит чуулганы болон завсарлагааны хугацаанд байгуулагдсан	2	3	-
2021 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан	-	8	-
2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан	-	4	-
Нийт - 23	3	19	1



2.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

Хүснэгт 3. Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	Ажлын хэсэг байгуулсан захирамж	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
1.	2021.03.02 №16 ЗАХИРАМЖ Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, Б.Жаргалмаа, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Х.Хэрлэн
2.	2021.03.11 №18 ЗАХИРАМЖ Концессын тухай хууль тогтоомж, гэрээний хэрэгжилтийг Дарханы төмөрлөгийн үйлдвэрт хэрхэн хэрэгжүүлж байгааг шалгах, санал, дүгнэлт гарган, шийдвэрийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Г.Дамдинням Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, Х.Болорчулуун, Х.Ганхуяг, Д.Өнөрболор, Г.Тэмүүлэн, Ч.Ундрэм, О.Цогтгэрэл ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Референт Д.Гэрэлт-Од
3.	2021.03.18 №21 ЗАХИРАМЖ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор газар эзэмших, ашиглахтай холбоотой газрын харилцааг зохицуулсан хууль тогтоомж болон Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Мөнхбат Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ш.Адъяаа, П.Анужин, Б.Бат-Эрдэнэ, Б.Жаргалмаа ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт К.Пүрэвсүрэн



2.1.1. Үйл ажиллагаа үргэлжилж буй ажлын хэсэг



2022 оны 5 дугаар сарын 01-нээс 7 дугаар сарын 06-ны хугацаанд ажилласан Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн үйл ажиллагааны мэдээлэл:

1. Улсын Их Хурлын даргын 2021 оны 16 дугаар захирамжаар байгуулагдсан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- Ажлын дэд хэсэг ЭМЯ, ХӨСҮТ, УОК болон УОК-ын дэргэдэх эрдэмтдийн зөвлөлөөс гаргасан мэдээллийг ажлын хэсгийн гишүүдэд тогтмол хүргүүлж байна.

- 2022.05.27-ны өдрийн байдлаар /КОВИД-19/-ын эсрэг вакцинд:
зорилтот бүлгийн:

- I тунгийн хамралт 96.4 хувь;
- II тунгийн хамралт 92.3 хувь;
- III тунгийн хамралт 53.3 хувь байна.

нийт хүн амын:

- I тун 69.9 хувь;
- II тун 66.9 хувь;
- III тун 32.2 хувийн хамралттай байна.

- 2022.06.08-ны өдрийн байдлаар /КОВИД-19/-ын эсрэг вакцинд:
зорилтот бүлгийн:

- I тунгийн хамралт 96.4 хувь;
- II тунгийн хамралт 92.3 хувь;
- III тунгийн хамралт 53.4 хувь байна.

нийт хүн амын:

- I тун 69.9 хувь;
- II тун 66.9 хувь;
- III тун 32.2 хувийн хамралттай байна.

- 2022.07.05-ны өдрийн байдлаар /КОВИД-19/-ын эсрэг вакцинд:
зорилтот бүлгийн:

- I тунгийн хамралт 96.5 хувь;
- II тунгийн хамралт 92.4 хувь;
- III тунгийн хамралт 53.4 хувь байна.

нийт хүн амын:

- I тун 69.9 хувь;
- II тун 66.9 хувь;
- III тун 32.3 хувийн хамралттай байна.



2. Улсын Их Хурлын даргын 2021 оны 18 дугаар захирамжаар байгуулагдсан “Концессын тухай хууль тогтоомж, гэрээний хэрэгжилтийг Дарханы төмөрлөгийн үйлдвэрт хэрхэн хэрэгжүүлж байгааг шалгах, санал, дүгнэлт гарган, шийдвэрийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- 2021.05.05-ны өдөр “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХК-иас ирүүлсэн тайлбарын дагуу нэмэлт судалгаа хийж, ажлын хэсгийн ахлагчид хүргүүлсэн.

- 2021.05.12-ны өдөр ажлын хэсгийн ахлагч тус үйлдвэр дээр ажиллахтай холбогдуулан дэд ажлын хэсгээс Концессын гэрээний хэрэгжилтийн одоогийн явц байдал, 2014-2020 оны төмрийн хүдрийн экспортын мэдээлэл, татварын өглөгийн дэлгэрэнгүй мэдээлэл, судалгааг бэлтгэн хүргүүлсэн.

- 2021.06.10-ны өдөр 2014 онд байгуулсан Концессын гэрээ, 2019 онд УУХҮЯ-наас байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлт болон “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХК-аас ирүүлсэн тайлбарт зэрэгцүүлсэн байдлаар санал, дүгнэлт боловсруулж ажлын хэсгийн ахлагчид хүргүүлсэн.

- Ажлын хэсэгт мэдээлэл ирүүлэх тухай ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Г.Дамдиннямын 2021.10.01-ний өдрийн УИХ-03/8688 дугаар албан бичгийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбатад хүргүүлж, хариу авсан.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

2.2. БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

Хүснэгт 4. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороо		
1	2021.12.24 №03 ТОГТООЛ Газрын тосны салбарын хөрөнгө оруулалт, экспорт, эрэл хайгуул, ашиглалт, олборлолт, байгалийн нөхөн сэргээлтийн асуудлаар газар дээр нь ажиллаж мэдээлэл авах, тулгамдаж буй асуудлыг судлан шийдвэрлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх зорилгоор Дорнод аймгийн Тамсагбулагийн сав газарт ажиллах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Э.Бат-Амгалан, Д.Ганбат, Н.Наранбаатар, Ц.Сэргэлэн, Б.Энх-Амгалан ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Д.Отгонбаатар, референт С.Төрмөнх
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо		
2	2022.04.13 №05 ТОГТООЛ Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт болон ус ашиглалтын талаар хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Саранчимэг Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Г.Ганболд, Н.Наранбаатар, Ц.Туваан, Т.Энхтүвшин ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт К.Пүрэвсүрэн
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо		
3	2021.01.13 №01 ТОГТООЛ Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 39 дүгээр тогтоолын 1.5 дахь дэд заалт “төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэж заасны хэрэгжилтийг хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Баярсайхан Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн П.Анужин, Ё.Баатарбилэг, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, Д.Өнөрболор, Ч.Ундрэм, Т.Энхтүвшин ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт К.Пүрэвсүрэн
4	2021.01.17 №03 ТОГТООЛ Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 5 дугаар сарын 03-ны өдөр баталсан Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна” гэж заасны хэрэгжилтийг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ч.Ундрэм Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн П.Анужин, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, Ж.Чинбүрэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт К.Пүрэвсүрэн

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
Нийгмийн бодлогын байнгын хороо		
5	2022.04.12 №09 ТОГТООЛ Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Баярсайхан Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн С.Ганбаатар, Б.Жаргалмаа, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Б.Саранчимэг, Ц.Туваан ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Х.Хэрлэн
6	2022.05.10 №12 ТОГТООЛ Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд эх, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах зэрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн П.Анужин Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Бейсен, Б.Жаргалмаа, Ц.Туваан, С.Одонтуяа ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Референт Х.Хэрлэн
7	2022.06.15 №17 ТОГТООЛ Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн харилцааны бүх шатанд олон талт түншлэлийг оновчтой, үр дүнтэй нэвтрүүлж, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлсэн эсэхийг хянан шалгах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн С.Ганбаатар Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Ц.Туваан, С.Чинзориг, Ч.Ундрэм ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Ц.Рэнцэнтогтох
Төсвийн байнгын хороо		
8	2020.11.04 №05 ТОГТООЛ Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийж, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Х.Булгантуяа Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, Х.Баделхан, Ж.Батсуурь, Г.Тэмүүлэн, Б.Чойжилсүрэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: ТХШХ-ийн ажилтнууд
9	2020.12.30 №07 ТОГТООЛ Төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилт, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 5.1.3, 8.3.15 дахь дэд заалтын биелэлтэд хяналт тавих зорилгоор төсвийн ерөнхийлөн захирагч болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2019-2020 оны үйл ажиллагааг хамруулан шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн С.Ганбаатар Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн С.Амарсайхан, Ц.Анандбазар, Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх М.Солонго, референт Д.Гэрэлт-Од

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
Хууль зүйн байнгын хороо		
11	2020.12.24 №09 ТОГТООЛ Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн С.Амарсайхан, С.Бямбацогт, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Д.Отгонбаатар
12	2021.03.15 №07 ТОГТООЛ Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг
13	2021.03.15 №08 ТОГТООЛ Гүйцэтгэх ажлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах явцад хүний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хариуцлага тооцох чиглэлээр хэрхэн ажиллаж байгаад үнэлгээ хийж, санал, дүгнэлт гаргах, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Энхбаяр Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг, С.Бямбацогт, Д.Ганбат, Б.Энх-Амгалан ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг
Эдийн засгийн байнгын хороо		
14	2021.10.27 №13 ТОГТООЛ “Дархан-Улаанбаатар хот хоорондын авто зам барих, ажлын явцыг эрчимжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, тодорхой асуудлаар үүрэг, чиглэл өгөх” үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Г.Дамдинням Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ж.Батжаргал, Д.Батлут, Б.Баттөмөр, Ч.Ундрэм ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: ХШХ-ийн дарга Ж.Лхагвасүрэн, зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Д.Отгонбаатар, референт С.Төрмөнх
15	2021.11.30 №17 ТОГТООЛ Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан "Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгаж, арилжааны банкуудад байршиж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн мөнгөн хөрөнгийг эрсдэлээс хамгаалах талаар санал, санал дүгнэлт гаргах" үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Г.Амартүвшин, Д.Батлут, Х.Булгантуяа, Т.Доржханд ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: ХШХ-ийн дарга Ж.Лхагвасүрэн, зөвлөх М.Солонго, референт Ч.Сарантуяа

2.2.1. Үйл ажиллагаа үргэлжилж буй ажлын хэсэг

2022 оны 5 дугаар сарын 01-нээс 7 дугаар сарын 06-ны хугацаанд ажилласан Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгүүдийн үйл ажиллагааны мэдээлэл:



1. БСШУСБХ-ны 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 39 дүгээр тогтоолын 1.5 дахь дэд заалт “төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэж заасны хэрэгжилтийг хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:

- 2022.05.09-ний өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар ажлын дэд хэсгийн үйл ажиллагааны явцын талаарх мэдээллийг сонссон. Мөн ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнийг өөрчлөн байгуулсан тухай БШУ, БХБ, БОАЖ-ын сайдын хамтарсан тушаалыг танилцуулж, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир ахалж ажиллахаар болсон.
- Ажлын дэд хэсгийн ахлагч Т.Ням-Очир ариун цэврийн байгууламжийн ажлын 1, 2 дугаар ээлжийн явц болон 3, 4 дүгээр ээлжийн ажлын талаарх төлөвлөгөө, болон орон нутагт ажиллах үед гарсан хүндрэл, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулсан.

2. ЭЗБХ-ны 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 13 дугаар тогтоолоор байгуулагдсан Дархан-Улаанбаатар хот хоорондын авто зам барих, ажлын явцыг эрчимжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, тодорхой асуудлаар үүрэг, чиглэл өгөх үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:

- 2022.05.06-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яаманд чиглэл өгөх тухай болон Гадаад харилцааны яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд авто замын бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэх гэрээ болон түүнд тавигдах шаардлага, тендер шалгаруулалтад оролцогч талуудын талаар тодруулга, мэдээлэл ирүүлэхийг хүссэн албан бичгийг тус тус хүргүүлсэн.
- Мөн ажлын хэсгээс үүрэг болгосны дагуу Дархан-Улаанбаатар чиглэлийн зам барилгын ажлын явцын талаарх 14 хоног тутмын мэдээллийг ЗТХЯ-наас ирүүлсэн.
- 2022.05.09-ний өдөр Зам, тээврийн хөгжлийн яам, бусад холбогдох байгууллагаас Дархан-Улаанбаатар чиглэлийн авто замын нөхцөл байдал, зам барилгын ажлын явцын талаарх мэдээлэл ирүүлсэн.
- 2022.06.06-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын бүтээн байгуулалтын ажлын явцын талаарх Зам, тээврийн хөгжлийн яамны мэдээллийг сонссон. Ажлын хэсгээс зам барилгын ажлын явцыг эрчимжүүлэх талаар Зам, тээврийн хөгжлийн яам болон холбогдох байгууллагуудад үүрэг, чиглэл өгсөн.
- 2022.07.04-ний өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын бүтээн байгуулалтын ажлын явцыг эрчимжүүлэх талаар Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яам, Тээврийн цагдаагийн албанаас мэдээлэл хийж, ерөнхий гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч компанийн санхүүжилт, иргэдийн хяналтын талаар хэлэлцээд холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгсөн.
- 2022.07.06-ны өдрийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яам болон замын ажлын ерөнхий гүйцэтгэгч компаниудад албан бичгээр тус тус хүргүүлсэн.



3. БОХХААБХ-ны 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар тогтоолоор байгуулагдсан Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт болон ус ашиглалтын талаар хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:



- 2022.05.10-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар ажлын хэсгийн төлөвлөгөөг хэлэлцэж, хаягдал ус цэвэршүүлэх байгууламж бүхий зарим байгууллагын үйл ажиллагаатай танилцахаар тогтсон.
- 2022.05.11-ний өдөр ажлын хэсэг "М Си Эс Кока Кола" ХХК болон "Амгалан дулааны станц" ТӨХК-ийн хаягдал ус цэвэршүүлэх байгууламжийн үйл ажиллагаатай танилцаж, цэвэршүүлсэн усыг хэрэглээнд бүрэн ашиглах, цэвэр усыг хэмнэх талаар санал солилцов.
- 2022.05.24, 31-ний өдөр ажлын хэсэг арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцахаар төлөвлөсөн ч зарим байгууллагуудын үйл ажиллагаа зогссонтой холбоотой, мөн ажлын хэсгийн гишүүдийн хурал давхацсан тул хойшлуулсан.

4. АБГББХ-ны 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 03 дугаар тогтоолоор байгуулагдсан Газрын тосны салбарын хөрөнгө оруулалт, экспорт, эрэл хайгуул, ашиглалт, олборлолт, байгалийн нөхөн сэргээлтийн асуудлаар газар дээр нь ажиллаж мэдээлэл авах, тулгамдаж буй асуудлыг судлан шийдвэрлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх зорилгоор Дорнод аймгийн Тамсагбулагийн сав газарт ажиллах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:



- 2022.05.18-ны өдрийн АБГББХ-ны хуралдаанд Тамсагийн сав газрын Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд үйл ажиллагаа явуулж байгаа "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон танилцуулав.
- 2022.05.24-ний өдрийн АБГББХ-ны хуралдаанд холбогдох газруудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн боловсруулсан ажлын хэсгийн үйл ажиллагааны тайланг танилцуулж, "Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай" Байнгын хорооны 03 дугаар тогтоолоор тЗасгийн газарт чиглэл өглсөн.

5. НББХ-ны 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:



- 2022.05.11-ний өдөр ажлын дэд хэсэг хуралдсан.
- Мөн ажлын хэсгийн гишүүн, НББХ-ны дарга М.Оюунчимэг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагаатай танилцсан.
- 2022.05.13-ны өдөр ажлын хэсгийн ахлагч Б.Баярсайхан Хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар УИХ-ын зарим гишүүдэд мэдээлэл өгсөн.
- 2022.05.16-ны өдөр ажлын хэсэг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт ажиллаж, үйл ажиллагааны тайланг сонссон.
- 2022.05.24-ний өдөр ажлын хэсэг Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ түр хамгаалах байр, 108 төвийн үйл ажиллагаатай танилцсан.
- 2022.05.31-06.04-ний өдрүүдэд ажлын хэсэг Завхан, Архангай, Өвөрхангай аймгуудын Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр, сургуулийн дотуур байрны үйл ажиллагаатай тус тус танилцав.



- 2022.06.20-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын тайлан, мэдээлэл үйл ажиллагаатай танилцсан.
- 2022.07.05 -ны өдөр Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагуулын танилцах ажлын хэсэг Хүүхдийн хорих анги, Хүүхэддэйн театрын үйл ажиллагаатай танилцсан.



6. БСШУСБХ-ны 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 5 дугаар сарын 03-ны өдөр баталсан Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна” гэж заасны хэрэгжилтийг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:

- 2022.05.25-ны өдөр ажлын хэсэг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 55 дугаар сургууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сувиллын цэцэрлэг, яслийн 10 дугаар цогцолбор, Монгол Улсын Боловсролын Их сургуулийн багш ажилтнууд, удирдлагуудтай уулзаж, үйл ажиллагаатай танилцсан.
- 2022.06.06-07-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын 3 дугаар сургууль, Улсын Тэргүүний 4 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж, хэрэгжүүлж буй арга хэмжээ, тулгарч буй асуудлын талаар санал солилцов.

Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тэгш хамран сурах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.



7. ТБХ-ны 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 05 дугаар тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийж, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:

- 2022.05.17-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанаас төсөвтэй холбоотой нэмэлт мэдээлэл бэлтгэж ирүүлэхийг Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус үүрэг болгосон.
- 2022.06.16-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамнаас ирүүлсэн мэдээлэл сонсож, ажлын дэд хэсэгт ажлын хэсгээс гарах санал, дүгнэлтийн төслийг боловсруулан танилцуулахыг үүрэг болгов.
- 2022.06.28-ны өдрийн Төсвийн байнгын хорооны хуралдаанд ажлын хэсгийн санал, дүгнэлтээ танилцуулсан. Байнгын хорооны гишүүдээс гаргасан саналыг тусгаж санал, дүгнэлтээ дахин танилцуулахаар болсон.



8. НББХ-ны 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 12 дугаар тогтоолоор байгуулагдсан Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд эх, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах зэрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:

- 2022.05.10-ны өдрийн 12 дугаар тогтоолоор байгуулагдсан Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд эх, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын

2.2.2. Үйл ажиллагаа дуусгавар болсон ажлын хэсэг



1. БОХХААБХ-ны 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 13 дугаар тогтоолоор байгуулагдсан "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах" үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:

- 2022.05.02-ны өдөр ажлын дэд хэсэг хуралдсан.
- 2022.05.03-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар ажлын хэсгийн санал, дүгнэлт, Засгийн газарт үүрэг, чиглэл өгөх тогтоолын төслийг хэлэлцэж, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтов.
- 2022.05.10-ны өдрийн БОХХААБХ-ны хуралдаанд ажлын хэсэг санал, дүгнэлтээ танилцуулж, Байнгын хорооны тогтоолоор чиглэл өгөх тухай тогтоолын төслийг хэлэлцүүлсэн. БОХХААБХ-ны 2022.05.10-ны өдрийн "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай" 08 дугаар тогтоолоор Засгийн газарт чиглэл өгснөөр ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.

2. НББХ-ны 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан Ахмад настны тухай, Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, Ахмад настны асрамжийн газрын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:

- 2022.05.04-ний өдрийн НББХ-ны хуралдаанд ажлын хэсгийн явцын тайланг ажлын хэсгийн ахлагч Б.Жаргалмаа танилцуулав.
- 2022.06.07-ны өдрийн НББХ-ны хуралдаанд ажлын хэсэг санал, дүгнэлтээ танилцуулж, Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцүүлэн батлуулсан. НББХ-ны 2022 оны 14 дүгээр тогтоолоор Засгийн газарт чиглэл өгснөөр ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.



3. Хөнгөн үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээний хүрээнд малыг эрүүлжүүлэх, сүүний үйлдвэрлэлийн салбарт төрөөс үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:

- 2022.05.12-ны өдөр "Эрүүл мал-чанартай сүү" сэдэвт хэлэлцүүлэг, уулзалтыг ҮББХ, ХХААХҮЯ-тай хамтран зохион байгуулсан.
- 2022.05.28-31-ний өдрүүдэд ажлын хэсэг ХХААХҮЯ, Мал эмнэлгийн ерөнхий газартай хамтран Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор батлагдсан "Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын хэрэгжилттэй танилцах, иргэдийн саналыг сонсох, цаашид сүүний салбарт төрөөс олгож буй мөнгөн урамшууллын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Төв аймгийн Аргалант, Лүн, Заамар, Цээл, Сүмбэр, Борнуур, Баянчандмань, Батсүмбэр сумдууд болон Булган аймгийн Баяннуур, Дашинчилэн, Бүрэгхангай сум, Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал сум, Дархан-Уул аймгуудад ажилласан.
- 2022.06.15-ны өдрийн ҮББХ-ны хуралдаанд ажлын хэсэг санал, дүгнэлтээ танилцуулж, Байнгын хорооноос гарах тогтоолын төслийг хэлэлцүүлэн батлуулсан. Байнгын хорооноос 2022 оны "Чиглэл өгөх тухай" 07 дугаар тогтоолоор Засгийн газарт чиглэл өгснөөр ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.



ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ



4. 06/03 дугаар тогтоолоор байгуулагдсан "Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын 2021 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны явц байдалтай танилцан, шалгаж, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий" БСШУСБХ, ТБХ-ны хамтарсан ажлын хэсгийн үйл ажиллагаа:

- 2021.10.19-ний өдрийн БСШУСБХ, ТБХ-ны хамтарсан хуралдаанд ажлын хэсгийн тайланг танилцуулж, Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцүүлсэн. Байнгын хорооноос шийдвэр гаргах шаардлагагүй гэж үзсэн тул ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.

2.3. ДЭД ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

Хүснэгт 5. Улсын Их Хурлын дэд хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо		
1	2020.10.26 №01 ТОГТООЛ Уурын болон усан халаалтын зуухтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Саранчимэг Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Т.Аубакир, Г.Ганболд, Г.Дамдинням, Ц.Туваан ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Ц.Рэнцэнтогтох



Монгол Улсын Их Хурлын
Хяналт шалгалтын тухай
хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1
дэх заалт, 12, 13 дугаар зүйл.

Улсын Их Хурлын гишүүдээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын даргад 10 асуулга тавьж, холбогдох албан тушаалтнаас 12 асуулга, 1 асуултын хариуг ирүүлсэн. Мөн 1 асуултын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын тогтоолоор Засгийн газарт чиглэл өгсөн. 3 асуулгын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн.

3.1. АСУУЛГА

- 2022.05.11-ний өдөр УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан Т.Энхтүвшин нараас Боловсрол, шинжлэх ухааны сайдад хандаж “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа Дорноговь аймаг дахь салбар сургуулийн талаар” тавьсан 21 дүгээр асуулга;
- 2022.05.20-ны өдөр УИХ-ын гишүүн М.Оюунчимэгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой бүтээн байгуулалтын ажлын талаар” тавьсан 22 дугаар асуулга;



<http://parliament.mn/n/tqbon>

- 2022.05.25-ны өдөр УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Засгийн газраас нүүрсний экспортыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон Хөгжлийн банкнаас fсанхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн зээлийн талаар” тавьсан 23 дугаар асуулга;
- 2022.05.26-ны өдөр УИХ-ын гишүүн Т.Энхтүвшин Б.Дэлгэрсайхан нараас Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад хандаж “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлын явц, түүнтэй холбоотой цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” тавьсан 24 дүгээр асуулга;
- 2022.06.02-ны өдөр УИХ-ын гишүүн С.Бямбацогтоос Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад хандаж “Хар ус нуурын ай савд нутагшуулсан Заарт хархны талаар” тавьсан 25 дугаар асуулга;



<http://parliament.mn/n/6nbon>

- 2022.06.02-ны өдөр УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатараас Монгол Улсын Шадар сайдад хандаж “Махны чанар, түүнд тавих хяналтын талаар” тавьсан 26 дугаар асуулга;
- 2022.06.03-ны өдөр УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Бат-Эрдэнэ, Б.Энхбаяр, Н.Энхболд нараас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Экспортын уул уурхайн бүтээгдэхүүний хяналтыг сайжруулах талаар” тавьсан 27 дугаар асуулга;



<http://parliament.mn/n/se4yn>

- 2022.06.09-ний өдөр УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн, Ё.Баатарбилэг, Ж.Мөнхбат, Ж.Чинбүрэн нараас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Хувийн хэвшил, орон нутгийн эмнэлгийн байгууллагуудад тулгамдаж буй асуудлын талаар” тавьсан 28 дугаар асуулга;
- 2022.06.17-ны өдөр УИХ-ын гишүүн Б.Баярсайханаас Эрүүл мэндийн сайдад хандаж “Хүн амын нийтийн эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай” тавьсан 30 дугаар асуулга;



<http://parliament.mn/n/jgnyn>

- 2022.07.05-ны өдөр УИХ-ын гишүүн С.Ганбаатараас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн талаар” тавьсан 31 дүгээр асуулга;

3.2. АСУУЛГЫН ХАРИУ



- 2022.04.12-ны өдөр УИХ-ын гишүүн Н.Алтанхуягаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Төрийн өмчийн талаар авч хэрэгжүүлж байгаа зарим арга хэмжээний тухай” тавьсан 14 дүгээр асуулгын хариуг 2022.05.13-ны өдрийн ХЭГ/1089 дугаар албан бичгээр;

<http://parliament.mn/n/71bon>

- 2022.04.13-ны өдөр УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Монгол Улсын Шадар сайдад хандаж “Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын талаар” тавьсан 16 дугаар асуулгын хариуг 2022.06.03-ны өдрийн ЗГ/320 дугаар албан бичгээр;
- 2022.04.14-ний өдөр УИХ-ын гишүүн М.Оюунчимэгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Эмийн үйлдвэрлэл, чанар, хяналт, хүртээмжийн зэрэг асуудал болон энэ талаарх цаашдын бодлого, зорилтын талаар” тавьсан 18 дугаар асуулгын хариуг 2022.05.05-ны өдрийн ХЭГ/1021 дүгээр албан бичгээр;
- 2022.04.18-ны өдөр УИХ-ын гишүүн Т.Доржхандаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Байгалийн хийн хоолой барьж байгуулах төслийн үйл явц, үр дүнгийн талаар” тавьсан 19 дүгээр асуулгын хариуг 2022.05.18-ны өдрийн ХЭГ/н-10 дугаар албан бичгээр;
- 2022.04.22-ны өдөр УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Монгол Улсын Шадар сайдад хандаж “Байгалийн хийн хоолой барьж байгуулах төслийн гэрээ хэлэлцээрийн үйл явц, Монгол Улсад өгөх үр өгөөжийн талаар” тавьсан 20 дугаар асуулгын хариуг 2022.05.13-ны өдрийн ЗГ-2/278 дугаар албан бичгээр;
- 2022.05.11-ний өдөр УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан, Т.Энхтүвшин нараас Боловсрол, шинжлэх ухааны сайдад хандаж “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа Дорноговь аймаг дахь салбар сургуулийн талаар” тавьсан 21 дүгээр асуулгын хариуг 2022.06.17-ны өдрийн 1а/2907 дугаар албан бичгээр;



- 2022.05.20-ны өдөр УИХ-ын гишүүн М.Оюунчимэгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой бүтээн байгуулалтын ажлын талаар” тавьсан 22 дугаар асуулгын хариуг 2022.06.17-ны өдрийн ХЭГ/1432 дугаар албан бичгээр;

<http://parliament.mn/n/e6nyn>

- 2022.05.25-ны өдөр УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Засгийн газраас нүүрсний экспортыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн зээлийн талаар” тавьсан 23 дугаар асуулгын хариуг 2022.06.27-ны өдрийн ХЭГ/1531 дүгээр албан бичгээр;
- 2022.05.26-ны өдөр УИХ-ын гишүүн Т.Энхтүвшин Б.Дэлгэрсайхан нараас Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад хандаж “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлын явц, түүнтэй холбоотой цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” тавьсан 24 дүгээр асуулгын хариуг 2022.06.10-ны өдрийн 01/1657 дугаар албан бичгээр;
- 2022.06.02-ны өдөр УИХ-ын гишүүн С.Бямбацогтоос Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад хандаж “Хар ус нуурын ай савд нутагшуулсан Заарт хархны талаар” тавьсан 25 дугаар асуулгын хариуг 2022.06.30-ны өдрийн 01/3721 дүгээр албан бичгээр;
- 2022.06.03-ны өдөр УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Бат-Эрдэнэ, Б.Энхбаяр, Н.Энхболд нараас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Экспортын уул уурхайн бүтээгдэхүүний хяналтыг сайжруулах талаар” тавьсан 27 дугаар асуулгын хариуг 2022.06.24-ний өдрийн ХЭГ/1519 дүгээр албан бичгээр.

<http://parliament.mn/n/hr4yn>



- 2022.07.05-ны өдөр УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн, Ё.Баатарбилэг, Ж.Мөнхбат, Ж.Чинбүрэн нараас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Хувийн хэвшил, орон нутгийн эмнэлгийн байгууллагуудад тулгамдаж буй асуудлын талаар” тавьсан 28 дугаар асуулгын хариуг 2022.07.07-ны өдрийн ХЭГ/1617 дугаар албан бичгээр;

3.3. АСУУЛТЫН ХАРИУ

- 2022.04.13-ны өдөр УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэнгээс Барилга, хот байгуулалтын сайдад хандаж “Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 6,7,13 дугаар хороодыг цэвэр, бохир усны шугамд холбох ажлын гүйцэтгэлийн талаар” тавьсан 15 дугаар асуултын хариуг 2022.05.06-ны өдрийн 1/2253 дугаар албан бичгээр;

3.4. АСУУЛТ, АСУУЛГЫН ХАРИУГ ХЭЛЭЛЦҮҮЛСЭН



- 2022.03.24-ний өдөр УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж “Ноос, ноолуурын салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Байнгын хорооны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар” тавьсан 08 дугаар асуултын хариуг 2022.04.27-ны өдөр Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар, 2022.05.06-ны өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар;

<http://parliament.mn/n/9a4yn>

- 2022.01.31-ний өдөр УИХ-ын гишүүн Н.Учралаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийн талаар” тавьсан 03 дугаар асуулгын хариуг 2022.05.13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар;



- 2022.03.31-ний өдөр УИХ-ын гишүүн Н.Энхболдоос Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж “Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар” тавьсан 10 дугаар асуулгын хариуг 2022.05.27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар;

<http://parliament.mn/n/osbon>

- 2022.03.17-ны өдөр УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэнгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар” тавьсан 07 дугаар асуулгын хариуг 2022.06.10-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар;

<http://parliament.mn/n/tnbon>



Монгол Улсын Их Хурлын
Хяналт шалгалтын тухай
хуулийн 15 дугаар зүйл

4.1. ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ

- 2022.05.20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хийх Ерөнхий сайдын мэдээллийн цагаар “Хувийн эрх зүйн шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар” Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар мэдээлэл хийв.

/Тайлбар: 2022.04.15-ны ХЭГ/817 бичгээр хойшлуулах, 2022.05.06-нд ХЭГ/1029 албан бичгээр хойшлуулах хүсэлт тус тус ирүүлж 2 удаа хойшлуулсан./

- 2022.06.03-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хийх Ерөнхий сайдын мэдээллийн цагаар “Цөлжилт, газрын доройтол, хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар” Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ мэдээлэл хийв.

4.2. БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНД СОНССОН МЭДЭЭЛЭЛ

- 2022.05.04-ний өдрийн НББХ-ны хуралдаанд “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайлан”-г Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга А.Ариунзаяа танилцуулав.
- 2022.05.10-ны өдрийн НББХ-ны хуралдаанд “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайлан”-г Эрүүл мэндийн сайд С.Энхболд танилцуулав.
- 2022.05.11-ний өдрийн БСШУСБХ-ны хуралдаанд “БСШУСБХ-ны 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 08 дугаар тогтоолын биелэлтийн талаар” Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Ц.Шаравжамц мэдээлэл хийв.
- 2022.05.11-ний өдрийн БСШУСБХ-ны хуралдаанд “Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны тухай” Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан танилцуулав.
- 2022.05.11-ний өдрийн БСШУСБХ-ны хуралдаанд “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь электрон тамхины хэрэглээ”-ний талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд мэдээлэл хийв.
- 2022.05.24-ний өдрийн ТБХ-ны хуралдаанд “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүнгийн талаар” Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Үндэсний аудитын газрын Аудитын 3-р газрын захирал Д.Энхболд нар мэдээлэл хийв.
- 2022.05.24-ний өдрийн ТБХ-ны хуралдаанд “МҮОНРТ-ийн 2017-2020 оны улсын төсвийн санхүүжилтийн хэрэгжилт, үр нөлөөний талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайлан”-г Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Үндэсний аудитын газрын Аудитын 4-р газрын захирал Я.Самбууням нар танилцуулав.
- 2022.06.07-ны өдрийн /КОВИД-19/-ын Түр хорооны хуралдаанд “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын нөхцөл байдал, шинэ төрөл, чиг хандлага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар” Эрүүл мэндийн сайд С.Энхболд мэдээлэл хийв.
- 2022.06.07-ны өдрийн НББХ-ны хуралдаанд “Хорт хавдрын өвчлөл, нас баралтын өнөөгийн байдал”-ын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд мэдээлэл хийв.
- 2022.06.15-ны өдрийн ХЗБХ-ны хуралдаанд “Хүний эрхийн Үндэсний Комиссын 21 дэх илтгэл”-ийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан танилцуулав.



5.1. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагааны тайлан, илтгэлд хийсэн шинжилгээ

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 14 дугаар зүйл.

1. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлд шинжилгээ хийсэн талаарх танилцуулга”-ыг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр ХЗБХ-нд хүргүүлэв;

2. “Шүүхийн сахилгын хорооны 2021 оны үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийсэн талаарх танилцуулга”-ыг ЕНБД-ын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн ТГ-01/636 дугаар албан бичгээр ТББХ-нд хүргүүлэв;

3. “Хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн байдлын талаарх Төрийн албаны зөвлөлийн 2021 оны тайланд шинжилгээ хийсэн талаарх танилцуулга”-ыг ЕНБД-ын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн ТГ-01/627 дугаар албан бичгээр ТББХ-нд хүргүүлэв;

4. “Улсын Их Хурлын Тамгын газрын 2021 оны үйл ажиллагааны тайланд системчилсэн үнэлгээ хийсэн талаарх танилцуулга”-ыг 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр ЕНБД-д хүргүүлэв;

5. Улсын Их Хурлын Тамгын газрын 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн талаарх танилцуулга”-ыг 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдөр ЕНБД-д хүргүүлэв.

Дараах хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж байна. Үүнд:

- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн /20 дугаар зүйл/ хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ;
- Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ;
- Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ.



Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын
тухай хуулийн Дөрөв дүгээр бүлэг
21 -24 дүгээр зүйл.



1. 2021 оны 05 дугаар сарын Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл, улсын төсвийн хөрөнгө оруулалт, Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл, орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлд шинжилгээ хийж танилцуулга бэлтгэсэн.

2. 2022 оны Монгол Улсын I улирлын бодит секторын үзүүлэлт, хөдөлмөрийн бүтээмж, гадаад худалдааны эргэлт, нэгдсэн төсвийн болон мөнгө, санхүүгийн үзүүлэлтүүд, гадаад валютын албан нөөц, төлбөрийн тэнцэл, хүн ам, ажил эрхлэлтийн үзүүлэлтүүдийг хамруулан макро эдийн засгийн танилцуулга бэлтгэсэн.

3. Монгол Улсын 2022 оны эхний 5 сарын гадаад худалдааны нийт бараа эргэлт, экспортын болон импортын нийт гүйцэтгэл, гол нэр төрлийн экспортын болон импортын бүтэц, бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээ, улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт, импортын татварын чөлөөлөлт зэрэг үзүүлэлтийг хамруулан танилцуулга бэлтгэв. Монгол Улс 2022 оны 05 дугаар сард нийт 142 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 7,221.0 сая ам.доллар, үүнээс экспорт 4,083.7 сая ам.доллар, импорт 3,137.3 сая ам.доллар боллоо. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1,295.4 (21.9%) сая ам.доллароор, экспорт 759.8 (22.9%) сая ам.доллароор, импорт 535.7 (20.6%) сая ам.доллароор тус тус өсжээ.

4. Монгол Улсын 2022 оны эхний 5 сарын улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн мэдээ бэлтгэв. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2022 онд нийт 1,393.8 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. 2022 оны 05 дугаар сарын гүйцэтгэлээр 396.4 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 169.4 тэрбум төгрөгийг зарцуулж 42.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

5. Засгийн газраас 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас ирүүлсэн Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланд тус тус үндэслэн шинжилгээ хийж танилцуулга бэлтгэсэн. Чуулганы нэгдсэн хуралдаанаар болон Байнгын хороодоор төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхтэй холбогдуулж, зардлын эдийн засгийн ангиллын дагуу тоон мэдээлэл боловсруулан товч танилцуулга бэлтгэж, холбогдох Байнгын хороодод хүргүүлж, гишүүдийг мэдээллээр ханган ажилласан.

6. ХЗБХ-оос дүн шинжилгээ хийлгэхээр ирүүлсэн Хүний эрхийн комисс, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны 2023 оны төсвийн төсөлд Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын шүүхийн тухай хууль, Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хууль болон холбогдох бусад тогтоол, журмыг үндэслэн дүн шинжилгээ хийж хүргүүлсэн.

7. 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр “Монгол Улсын төлбөрийн тэнцлийг сайжруулах нь өрийн удирдлагын үндсэн зарчим” сэдэвт хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын Тамгын газар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хамтран зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Олон улсын валютын сангийн төлөөлөгч ноён Юн Сок Хёнг, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Монгол Улсын ерөнхий аудитор Д.Занданбат, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Э.Бямбажав нар илтгэл тавьж, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, төр захиргааны байгууллагын ажилтнууд, эрдэмтэн судлаачид, олон нийтийн болон Олон улсын байгууллагын төлөөлөл Монгол Улсын өрийн удирдлагыг боловсронгуй болгохтой холбоотой тодорхой саналуудыг гаргаж, зөвлөмж өгсөн. Хэлэлцүүлэгт оролцогчдын гаргасан санал, өгсөн зөвлөмжийг нэгтгэж, холбогдох төр, захиргааны байгууллагуудад хүргүүлэх бэлтгэлийг хангаж ажиллаж байна.

